



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

“Өвханын материал” ХК-ийн нэгдмэл сонирхолтой¹
хувьцаа эзэмшигчдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг
худалдан авахаар гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Өвханын материал” ХК-ийн нийт гаргасан 107,306 ширхэг хувьцааны 65,91 хувь буюу 70,739 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Пак Чан Сү, Чан Кён Сүк нараас тус компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 34.09 хувь буюу 36,567 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 /нэг зуу/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоосугай.


2. “Өвханын материал” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргах ажиллагаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Пак Чан Сү/-д үүрэг болгосугай.

1/ Компанийн тухай хуулийн 57.3 дахь хэсэгт заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт буюу 2012 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн дотор худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН